

МОНГОЛЫН СЭТГҮҮЛЧИЙН УР ЧАДВАРТ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД

М.Зулькафиль*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн тэргүүлэх профессор, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн

Түлхүүр үг: сэтгүүлчийн ур чадвар, агуулга ба хэлбэр, арга зүй ба арга, хэрэглэдэг “уруугаа харсан пирамид”, “эрчимт хөдөлгөөний нэгдэл”.

Ур чадвар бол бүтээлч үйл ажиллагааны аль ч салбар, хүрээнд байдаг нэлээд өргөн агуулга бүхий нийтлэг ойлголт юм. Аливаа зүйлийг тодорхой шаардлагын төвшинд урлан бүтээх чадварыг маш энгийнээр ур чадвар гэж ойлгож болно. Тиймээс оюуны бүтээлч хөдөлмөрийн өвөрмөц салбар, мэдээллийн үйл ажиллагааны тодорхой нэг төрөл болох сэтгүүл зүйн хувьд ур чадвар хэмээх ойлголт онцгой байр эзэлдэг. Ерөөсөө сэтгүүл зүйд ур чадвараас үл хамаарах зүйл гэж үгүй. Сэдвээ сонгох, мэдээлэл цуглуулахаас эхлээд нийтлэл, нэвтрүүлгийг олон түмэнд хүргэх хүртэлх бүхий л үйл ажиллагаа сэтгүүлчийн ур чадвараас шууд шалтгаална. Энэ утгаар нь авч үзвэл сэтгүүлчийн ур чадвар гэдэг бол түүний бүтээлч үйл ажиллагааны дээд төвшний тухай, энэ үйл ажилла-

гааны зүй тогтлыг тал бүрээс нь бүрэн тодотгох тухай, урлан бүтээхийн хамгийн идэвхтэй илрэлийн тухай асуудал юм. Ур чадвар гэдэг ойлголт нь өргөн утгаараа нийгмийн дэвшлийн практикт бүрэн тохирсон, хүний үйл ажиллагааны өндөр дээд төвшинд хүрэн ажиллах чадвар болно. Товчоор хэлбэл, ур чадвар гэдгийг аливаа бүтээлийн чанарын шалгуур гэж ойлгож болно. Тухайн бүтээлийн сайн, муу эсэхийг бид түүний ур чадвартай холбон ойлгох явдал чухам үүнтэй холбоотой юм. Манай нэрт сэтгүүлчийн үгээр хэлбэл “...Ур чадвар бол удаан жилийн зузаан туршлагаар бий болдог мэргэшлийн эрдэм буюу өөрийн болгож шингэж авсан арга ухаан, эв дүй, танин мэдэхүй мөн”¹.

Сэтгүүлчийн ур чадвар гэдэг нь баримтыг сонгон цуглуулах, олсон баримтаа тайлбарлах, ургуулан бодох авьяас, уг үзэгдлийн дотоод мөн чанарт нэвтрэн орох, таамаглах, магадлах, учир шалтгааныг тодруулах чадвар юм. Өөрөөр хэлбэл, “Сэтгүүлчийн ур чадвар гэдэг бол баримтаар хүлээн авагчдыг

итгүүлэн үнэмшүүлэх буюу бодит байдлаас гол баримтуудыг сонгох, нэгтгэх, задлан шинжлэх, тэдний харилцаа холбоо, харилцан нөлөөллийг тогтоох, үүний үндсэн дээр өөрийн санаа бодол, үзэл баримтлалыг дэвшүүлэн тавих чадвар² мөн. Нийтлэл бичих арга нь сэтгүүлчийн үйл ажиллагааны ихээхэн субъектив шат бөгөөд энэ шатанд сэтгүүлч судалж буй сэдвийнхээ агуулгын янз бүрийн хэлбэрийг олж нээх онцлогтой. Ингэхэд нь мэдээж онолын, туршилтын, шинжлэх ухааны, уран сайхны, сэтгэл хөдлөлийн зэрэг бодит юмсыг тусгах хүний сэтгэлгээний хэлбэрүүд тусалдаг.

Сэтгүүлчийн ур чадвар гэдэг бол зөвхөн хэлбэрийн буюу урлан бичих ур чадвар биш, харин хэлбэрийг зөв гаргах ур чадвар юм. Энэ бол агуулга хэлбэрийн нэгдлийг өндөр төвшинд хангах явдал гэсэн үг мөн. Сэтгүүлчийн аливаа нийтлэл нь үүрэг—зорилго—сэдэв—арга—агуулга—хэлбэр гэсэн үндсэн ойлголтуудын гинжин хэлхээнээс тогтодог. Аливаа бүтээлийг урлан бүтээх энэхүү зүй тогтолт ойлголтуудыг зохиол бүтээлдээ хэрхэн хэрэгжүүлсэн байдлаар нь сэтгүүлчийн ур чадварын төвшин, онцлогийг үнэлэн цэгнэдэг боломжтой. Дээр дурдсан ойлголтуудын аль нэгийг оновчтой сонгож чадаагүй, хагас дутуу судалсан, учир дутагдалтай хандсан нөхцөлд сэтгүүлчийн ур чадвар бүрэн төгс болж чадахгүйн дээр чанаргүй, үлбэгэр бүтээл гарах гол үндэс болдог онцлогтой. Энэ зургаан элементийн дотор хамгийн гол шийдвэрлэх үүргийг арга гүйцэтгэдэг. Сэтгүүлчийн нийтлэл бичих арга нь ямар байгаагаас

түүний ур чадвар шалтгаалах болно. Өөрөөр хэлбэл, аргын тусламжтайгаар үүрэг—зорилго—судлагдахууныг тодорхойлж, дараах хоёр элемент болох агуулга—хэлбэр хоёрын нэгдлийг хангах учраас нэн чухал үүрэгтэй гэдэг нь ойлгомжтой.

Аргыг хамгийн ерөнхий утгаар тодорхойлбол “агуулга, хэлбэрийн нэгдэл бүхий чамбай сайн нийтлэл бүтээхийн тулд өрнүүлж буй нийтлэгчийн бүтээлч ажиллагааны арга буюу урлан бүтээхдээ ашиглаж байгаа мэдлэгийн нийлбэр цогц”³ юм. Тийм учраас энэ нь ур чадварын онолыг боловсруулахад онцгой нөлөөтэй гол үндсэн ойлголт мөн.

Нийтлэл бүтээх үйл ажиллагаа сэдвээсээ эхэлдэг. Сэдэв бол сэтгүүлчийн санааг эзэмдэж, сэтгэлийг гижигдэж буй тодорхой үзэл баримтлал мөн. Амьдрал өөрөө дэвшүүлэн тавьж буй тэрхүү сэдэв нь сэтгүүлчээс түүнийг боловсруулах, дооод мөн чанарт нь нэвтрэх ур ухаан шаардана. Сэдвийг боловсруулах нь зайлшгүй шаардлагатай баримт мэдээллийг олж, түүнийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж, нийтлэлийн хэлээр тайлбарлана гэсэн үг бөгөөд сайтар судалсан баримтын логик өөрөө нийтлэл бүтээх ерөнхий загварыг бий болгодог. Энэ нь зохиогчийн ухамсар, мэдлэг боловсрол, дадлага туршлагаас шууд шалтгаалах болно. Өөрөөр хэлбэл, “Сэтгүүлчийн уран чадварын их хүч тэнхээ, билиг авьяасаар шаргуу хөдөлмөрийн үр дүнд бий болсон бүтээлүүд бол нийгэмд соёлын үнэт зүйлийг арвижуулах нэмэр хандиваар зогсохгүй, өөрөө тэр соёлын үнэт зүйлс болон хувирах”⁴ учиртай юм.

Сэтгүүлч хүн бас агуулга, хэлбэрийн харилцан нөлөөлөл, хамаарлыг сайн мэдэж байх нь чухал. Үүнд сэдвийн агуулгыг бүтээхэд хэлбэрийг чадамгай ашиглахын зэрэгцээ агуулга өөрөө шаардлагатай хэлбэрийг сонгоход тодорхой хэмжээгээр нөлөөлж буйг мэдрэх чадвартай байх ёстой. Эс тэгвэл агуулга, хэлбэр хоёр хоорондоо зөрчилдөх, үр өгөөжгүй, чанаргүй бүтээл төрөх аюултай. Ер нь агуулга, хэлбэрийн оновчтой нэгдлийг хангахад бидний дээр дурдсан “арга” хэмээх төв элемент гол үүрэг гүйцэтгэдэг. Эндээс бид нийтлэлийн агуулга, хэлбэрийн харилцан нөлөөлөл бол диалектик үйл явц мөн гэсэн дүгнэлт хийх бүрэн үндэстэй юм. Үүнийг хэрхэн үр өгөөжтэй хэрэглэх нь сэтгүүлчийн ур чадварын нэг гол шалгуур болох учиртай. Өргөн утгаар нь ур чадвар гэдгийг аливаа бүтээлийн чанарын шалгуур, агуулга хэлбэрийн нэгдлийн илэрхийлэл мөн. Тиймээс ур чадварыг *агуулга + хэлбэр = ур чадвар* гэж тодорхойлж болно.

“Ур чадвараа хөгжүүлнэ гэдэг бол бодол санаагаа төгөлдөржүүлэх, зорилгоо хөгжүүлэх, баримт, үзэгдлийг гүнзгий ухаж ойлгоход ухаанаа зангидаж сурах явдал мөн”⁵ гэж Оросын нэрт зохиолч, сэтгүүлч Н.Г.Чернышевский тэмдэглэсэн байдаг. Энэ бол сэтгүүлчийн ур чадварын тухай ярихад юуны өмнө эргэцүүлэн ёсдож үзмээр онц мэргэн тодорхойлолт юм. Сэтгүүлчийн ур чадварыг тодорхойлох, түүнд нөлөөлөх олон хүчин зүйл, салшгүй бүрэлдэхүүн хэсгүүд байдаг. Тэдний дотор агуулга болон хэлбэр хэмээх ойлголт онцгой үүрэгтэй гэдгийг дээр дурдсан билээ.

Сэтгүүлчийн ур чадварын тухай ярихдаа түүний арга зүйн асуудлыг авч үзэх зайлшгүй шаардлагатай бөгөөд ур чадварын арга зүй гэдэг бол өөрийн өвөрмөц шинж бүхий харьцангуй бие даасан асуудал мөн. Үүнийг нэгэн хандлага бүхий хоёр чиглэлд авч үздэг. Нэгдүгээрт, ур чадварын арга зүй гэдэг нь нийтлэл бүтээх онолыг логик дараалалд оруулсан аргуудын нийлбэр цогц мөн. Энэ хэсэгт нийтлэл бүтээхэд шаардлагатай онол болон баримтлах зарчмууд гол үүрэг гүйцэтгэдэг. Хоёрдугаарт, нийтлэл бүтээх үйл ажиллагааны янз бүрийн хэлбэр, төвшинд хэрэглэж буй аргууд бол бодит байдлыг танин мэдэх үйл явц мөн гэж ойлгох нь чухал ач холбогдолтой. Энэ хоёр чиглэл хоорондоо нягт уялдаа холбоотой, нэгдмэл зүйл байдаг.

Сэтгүүлчийн ертөнцийг үзэх үзэл нь түүний нийгмийн, бас танин мэдэхүйн байр суурийг тодорхойлж байдаг учир нийтлэл, нэвтрүүлэг бүтээх аргын гол үндэс суурь нь болдог онцлогтой. Ертөнцийг үзэх үзэл хүний оюун санаа, практик үйл ажиллагаа, нийгмийн амьдралын бүхий л хүрээтэй холбоотой түүний зан үйлийг удирдан хөтөлж байдаг. Тиймээс сэтгүүлчийн ертөнцийг үзэх үзэл нь түүний үйл ажиллагааны үндэс, уран бүтээлийн чиглэл, шинж чанар, агуулга хэлбэрийг тодорхойлж байдаг.

Нийтлэл бүтээх өвөрмөц хөдөлмөр бол сэтгүүлчийн ертөнцийг үзэх үзлийн, тухайн ОНМХ-ийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогын, уран бүтээлчийн өвөрмөц арга барилын гэсэн гурван үе шатыг дамжин хэрэгждэг онцлогтой юм.

Сэтгүүл зүй бол мэдээллийн бүтээлч үйл ажиллагаа болохын хувьд түүний үнэн бодитой байх, шуурхай, хүртээмжтэй байх, ил тод, олон ургальч шинжтэй байх, хүнлэг, олон нийтэч байх, тэнцвэрт байдлыг хадгалах зэрэг үндсэн зарчмуудын тухай мэдлэгийг практикт бүтээлчээр хэрэгжүүлэх явдал бол арга зүйн асуудал мөн. Учир нь энэ зарчмууд нийтлэл бүтээхдээ амьдралын юмс, үзэгдэлд ямар байр сууринаас хандах, сэдвээ яаж сонгох, баримтыг хэрхэн тусгах, юмс үзэгдэл, үйл явдлыг хэрхэн үнэлэхэд гол тулгуур үндэс нь болдог. Өнөөдөр манай зарим ХМХ асуудлын нэг талыг барьж туйлширдаг, сэтгүүлч аль нэг баримтыг өөрийнхөө үзэл бодолд тохируулан тайлбарлаж, хэмжээнээс хэтэрсэн үнэлэлт дүгнэлт хийдэг нь хэвлэл мэдээллийн газрын нийтлэлийн бодлоготой шууд холбоотой бөгөөд энэ нь мэдээллийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, олон түмэнд буруу зөрүү ойлголт өгдөг сөрөг талтай юм. Ийм хандлага 2008 оны УИХ-ын ээлжит сонгуулийн дараах үймээн самуун болон Монгол Улсад онц байдал тогтоосон үед улам тод ажиглагдаж, манай ХМХ-үүд улс төрийн нам, эвсэл хөдөлгөөнүүдийн, улс төрчдийн үзэл бодлыг хамгаалсан, өмөөрсөн, эсвэл шүүмжилж, харааж зүхсэн индэр болж хувирсан нь олон түмэнд нэг талыг барьсан мэдээлэл өгч,

нийгэм дэх улс төрийн уур амьсгалыг ээдрээтэй болгоход тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.

Ерээд оноос хойш Монголын ОНМХ-ийн систем, үүрэг, зарчим, нийтлэл нэвтрүүлгийн агуулга төдийгүй, нийтлэлийн хэлбэр хэмжээ, бичлэгийн ур чадвар, төрөл зүйлд хүртэл томоохон өөрчлөлт гарсан билээ. Сэтгүүлчийн ур чадвар сэтгүүл зүйн хөгжил дэвшил, тусгах объектэд гарсан өөрчлөлт, сэтгүүлч уран бүтээлчдийн мэдлэг боловсрол, дадлага туршлага, авьяас чадвараас шалтгаалан байнга баяжин гүнзгийрч, шинэчлэгдэж байдаг өвөрмөц ойлголт бөгөөд нийтлэл, нэвтрүүлгийн бүтэц зохиомж, хэлбэр, төрөл зүйлд нөлөөлж байдаг өвөрмөц ойлголт юм. Өөрөөр хэлбэл, бичлэгийн төрөл зүйл нь

«

Сэтгүүл зүй бол мэдээллийн бүтээлч үйл ажиллагаа болохын хувьд түүний үнэн бодитой байх, шуурхай, хүртээмжтэй байх, ил тод, олон ургальч шинжтэй байх, хүнлэг, олон нийтэч байх, тэнцвэрт байдлыг хадгалах зэрэг үндсэн зарчмуудын тухай мэдлэгийг практикт бүтээлчээр хэрэгжүүлэх явдал бол арга зүйн асуудал мөн.

»

сэтгүүлчийн уран чадвараас шууд шалтгаалдаг гэсэн үг. Сүүлийн хориод жилд манай оронд чөлөөт сэтгүүл зүйн эх суурь тавигдаж, коммунист сэтгүүл зүйн нийгэмд гүйцэтгэх үүрэг, баримтлах зарчим, тусгах объектээс нь эхлээд бараг бүх бүрэлдэхүүн хэсэг нь эрс өөрчлөгдсөн нь хамгийн түрүүнд бичлэгийн төрөл, зүйл хүчтэй өөрчлөгдөхөд нөлөөлсөн. Сэтгүүл зүйн практикт ахар богино хугацаанд нэлээд эрчимтэй нэвтэрсэн олон ургальч үзэл, ил тод байдал, үгийн эрх чөлөө нь нийтлэл,

нэвтрүүлгийн агуулга ба бичлэгийн арга барилд чөлөөт байдлыг авч ирсэн билээ. Сэтгүүл зүйн мэдээлэх үүргийн ач холбогдол эрс нэмэгдэж, мэдээллийн шуурхай чанар тэргүүн зэргийн шаардлагын төвшинд тавигдах болов.

ОНМХ-үүдийн хооронд өрнөсөн хүчтэй өрсөлдөөн нийтлэл, нэвтрүүлгийн чанарт эерэг ч, сөрөг ч нөлөө үзүүлж, мэдээлэл таваар болон хувирсан юм. Сайн тал нь мэдээллийн шуурхай, хүртээмжтэй байдал мэдэгдэхүйц дээшилж, хэвлэл мэдээллийн байгууллагууд хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, сонирхлыг тодорхой хэмжээгээр харгалзан үзэх болов. Энэ нь нийтлэл, нэвтрүүлгийн сэдвийн хүрээ өргөжих, мэдээллийн багтаамж дээшлэх, сонин хэвлэлийн өнгө үзэмж сайжрах зэрэг эерэг өөрчлөлт гарахад нөлөөлжээ.

Сөрөг тал нь ОНМХ-ийн тоо богино хугацаанд хэт олширч, нийтлэл, нэвтрүүлгийн бичлэгийн төрөл зүйл явцуурч, хэл найруулга нь муудаж, сэтгүүл зүйн мэргэжлийн төвшин сайн дурын уран сайханчдын хэмжээнд хүрсэн. Сүүлийн үед бага зэрэг сайжрах хандлага ажиглагдаж байгаа боловч чанарын шаардлагын төвшинд хүрэхэд эндүү хол байна.

Эхлээд сэтгүүлчийн ур чадварт гарсан үндсэн өөрчлөлтийн талаар товч өгүүлье. Сэтгүүлчийн ур чадвар гэдэг бол өргөн утгаар нь агуулга ба хэлбэрийн нэгдлийн асуудал учраас сэтгүүл зүйн тусгаж буй объектийн шинж чанар, бичлэгийн төрөл зүйлд гарсан өөрчлөлт гэдэг бол цаад утгаараа сэтгүүлчийн ур чадварт гарсан өөрчлөлт гэсэн үг. Энэ утгаараа авч

үзвэл манай сэтгүүлчдийн ур чадварт томоохон өөрчлөлт гарсан нь тодорхой юм.

Сэтгүүлчийн ур чадварт гарсан нэг гол өөрчлөлт бол нийтлэл, нэвтрүүлгүүд удирдан чиглүүлсэн, уриа лоозон дэвшүүлсэн, тайлагнан мэдээлсэн албархуу шинж, зөвхөн ололт амжилтыг дөвийлгөн сурталчлахыг чухалчилсан саарал магтаалын өнгө аясаас ангижирч, аль ч асуудалд чөлөөтэй хандах, зохиогч өөрийн санаа бодол, үнэлэлт дүгнэлтийг чөлөөтэй тусгах болсон. Бичлэгийн нэг хэв загварт баригдсан арга хэлбэр, социалист уралдааны дүн, тэргүүн туршлага, таван жилийн төлөвлөгөөний биелэлт зэрэг жижүүрийн хэдэн сэдвийн хүрээнд эргэлддэг ХМХ-үүд нийгмийн аль ч хүрээ салбар руу эрчимтэй нэвтэрч, тусгах асуудлын хүрээ өргөжих хандлага ажиглагдаж эхэлсэн. Өөрөөр хэлбэл сэтгүүл зүй нэг намын үзэл суртлын зэвсгээс мэдээллийн индэр, нийгмийн “хоточ нохой”, сэтгүүлчид үзэл суртлын фронтын дайчин байлдагчаас ард түмний “нүд, чих” болон хувирах үндэс суурь тавигдсан нь сэтгүүлчийн ур чадварт нөлөөлөх гол хүчин зүйл болсон юм. Нийгмийн тогтолцоонд гарсан өөрчлөлтөөс урган гарсан энэхүү хүчин зүйл нь сэтгүүлчийн ур чадварт эерэг ч, сөрөг ч нөлөө үзүүлсэн юм.

Сэтгүүлчид харьцангуй товч бичдэг болсон. Уянгын халил, үнэлэлт дүгнэлт ихтэй нуршуу бичлэг, хурал цуглааны тайлан, дарга нарын илтгэл, өгүүлэл, ажлын үр дүнг илтгэсэн мэдээлэл, баяр ёслол, дайлага цайллагын тухай албархуу тэмдэглэл багасч, мэдээллийн бичлэгийн шуурхай төрөл, зүйлүүд

голлох хандлага нэлээд эрчимтэй явагдах болсон. Энэ бол уншигч, үзэгч, сонсогчдын мэдээлэл хүлээн авах боломж нь нэмэгдэж, мэдээллийн шуурхай чанар, багтаамж нь мэдэгдэхүйц дээшилж, ХМХ-үүдийн хооронд өрсөлдөөн бодит үзэгдэл болсонтой холбоотой юм. Орчин үеийн дэлхий дахины сэтгүүл зүйн өмнө тавигдаж буй чухал зорилтын нэг нь мэдээллийн багтаамжийг дээшлүүлэх, улам шуурхай, хүртээмжтэй болгох явдал бөгөөд ийм нөхцөлд манай сэтгүүл зүй өөрөөр ажиллах аргагүй юм. Гэхдээ мэдээллийн багтаамжийг дээшлүүлэх, шуурхай болгох нэрийн дор хэрэгтэй хэрэггүй зүйлээр сонины зай талбайг бөглөх, аахар шаахар зүйлээр нэвтрүүлгийн цагийг нөгцөөх явдал түгээмэл байна. Тиймээс манай ХМХ-үүдийн нийтлэл, нэвтрүүлгийн хэмжээ багассаныг шууд утгаар нь мэдээллийн багтаамж дээшилсэн гэж дүгнэхэд арай эрт байна. Харин зарим нэг сонин хэвлэлийн нийтлэлд нааштай өөрчлөлтүүд гарч байгааг хэлэх хэрэгтэй. Тооноос чанарт шилжих, чанараас үр дүнд хүрэхийн төлөө манай ХМХ-үүдэд шинэ менежмент, шинэ сэтгэлгээ, идэвх санаачилга, бичлэгийн цоо шинэ арга барил шаардлагатай бөгөөд одоохондоо ийм хандлага ихэнх сонин хэвлэл, радио, телевизэд ажиглагдахгүй байна.

Барууны сэтгүүл зүйд түгээмэл хэрэглэдэг бичлэгийн арга барил Монголын сэтгүүл зүйн практикт тодорхой хэмжээгээр нэвтэрч эхэлсэн. Өнөөдөр манай ХМХ-д мэдээллийн бичлэгийн төрөлд түгээмэл хэрэглэдэг “уруугаа харсан пирамид” (лид, их бие, төгсгөл), “эрчимт

хөдөлгөөний нэгдэл” (туйл, шалтгаан, үр дагавар) зэрэг бүтцийг өргөн ашиглаж байна. Мөн ток шоу, шууд ярилцлага, теле аян замын тэмдэглэл зэрэг төрөл ч радио, телевизийн нэвтрүүлэгт гол байр эзлэх болов. Энэ бол манай ХМХ-үүд дэлхийн сэтгүүл зүйн хөгжилтэй хөл нийлүүлэн урагшилж буйн нэг тодорхой илрэл гэж хэлж болно. Гэхдээ ийм шинэлэг үйл ажиллагаа, арга барил манай зарим ХМХ-д, ялангуяа орон нутгийн болон олон нийтийн байгууллагын, салбарын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд учир дутагдалтай байна. Өөрсдийн алдаа дутагдлыг бусдад тохох, шалтгааныг бусдаас эрж хайх, идэвх санаачилга гарган эрэл хайгуул хийхийн оронд хэн нэгнээс тус дэмжлэг хүсэн хүлээж суух, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, бусдаас суралцах асуудалд нэлээд хайнга, бэлэнчлэх сэтгэлгээгээр хандах зэрэг ажлын хуучинсаг арга барил энэ ХМХ-үүдэд амь бөхтэй оршиж байна.

Сэтгүүлчид аливаа асуудалд хандах, сэдэв, баримт сонгохдоо хүлээн авагчдын оюуны эрэлт хэрэгцээ, сонирхол, цаг үеийн шаардлагыг юуны өмнө харгалзан үздэг болсон нь нэн шинэлэг хандлага юм. Өөрөөр хэлбэл нам, төр засгийн бодлогод тохируулан дээрээс өгсөн заавар зөвлөмжийн дагуу бичдэг, хүлээн авагчдын мэдээллийн эрэлт хэрэгцээг ямагт хоёрдугаарт тавьж ирсэн хуучин цагийн бичлэгийн арга барилаас сэтгүүлчид үндсэндээ ангижирсан гэж хэлж болно. Энэ бол нэг талаар олон ургальч үзэл, ил тод байдал хэвийн үзэгдэл болж, чөлөөт хэвлэлийн эх суурь тавигд-

сантай, нөгөө талаар мэдээлэл болон ХМХ-ийг эрхлэн явуулах үйл ажиллагаа бизнес болж хувирсантай холбоотой юм. Цаашид ийм хандлага улам эрчимжих болно. Гэхдээ энд нэг зүйлийг тэмдэглэн хэлэхэд ХМХ-үүд уншигчдыг шинэ мэдээллээр шуурхай хангах, танин мэдэхүйн хүрээг өргөжүүлэх, гэгээрүүлэхээсээ илүү сэтгэл зүйгээр нь тоголж сониноо борлуулах, захиалагчдын тоог нэмэгдүүлэх гэсэн хандлага давамгайлсан хэвээрээ байна.

Бүтэц зохиомжийн хувьд хэт чөлөөтэй, нээлттэй, задгай зохиомжтой бичвэрүүд эрс нэмэгдсэн. Энэ нь олсон бүх баримтыг нэгбүрчлэн тоочих, дотоод логик холбоо алдагдах, хүлээж авахад ихээхэн хүндрэлтэй мэдээ материал олшроход хүргэж байна. Болж өнгөрсөн үйл явдлыг гол төлөв цаг хугацааны дэс дарааллын дагуу тоочих явдал голлох болсноос онцын ач холбогдолгүй зүйлүүдийг хүчээр оруулах, хэрэггүй юмаар хэт жижигрэх, аахар шаахар зүйлийг нурших явдал газар авсан. Энэ бол өөрийгөө “чөлөөт” гэж нэрлэдэг шар сониныг эс тооцоход өдөр тутам гардаг чанартай, нөлөө бүхий сонинуудад ч түгээмэл ажиглагдах дутагдал гэж хэлж болно. Нийтлэл, нэвтрүүлгийн ийм хэт чөлөөтэй, задгай зохиомж нь сэтгүүлчдэд чөлөөтэй бичих, сэтгэх боломж олгодог гэсэн утгаараа сайн талтай боловч агуулга хэлбэрийн нэгдэл зөрчигдөх, баримт үйл явдлын дэс дараалал алдагдах, үндсэн мэдээллээс илүү зохиогчийн үзэл бодол, тайлбар давамгайлах, уншигчдад буруу зөрүү ойлголт өгөх зэрэг сөрөг үр дагаварт хүргэж байна. Энэ бол аливаа юманд хэмжээ

хязгаар байгааг харуулж буй хэрэг мөн. Үүнд нөлөөлж буй гол шалтгааны нэг бол сэтгүүлчид шуурхай мэдээлэл нэрийн дор нийтлэлийн чанарыг үл хайхран дураараа загнаж, дээр нь редакцийн газрууд ч үүнд дөжирсөн явдал юм. Ийм хандлага чанаргүй, үр өгөөжгүй нийтлэл, нэвтрүүлэг хэт олшроход гол үүрэг гүйцэтгэж байна.

Ө нөөдөр Монголын сэтгүүл зүйн нэр хүндийг гутааж, мэргэжлийн чанарт сөрөг нөлөө үзүүлж буй гол хүчин зүйл бол нийтлэл, нэвтрүүлгийн хэл найруулга, сэтгүүлч, хөтлөгчдийн ярианы соёл, чадвар юм. Бараг амтай болгон энэ талаар ярьж шүүмжилдэг боловч, манай сонин хэвлэл, радио телевизийн хэл найруулга улам муудсаар байна. Одоогоос хэдэн жилийн өмнө үүнийг нэлээд боловсролтой, сонин хэвлэл уншдаг хүмүүс шүүмжилдэг байсан бол өдгөө бараг бичиг үсэг мэддэг хүн болгон шүүмжилдэг болсон нь манай сэтгүүл зүйн нийтлэл, нэвтрүүлгийн хэл найруулга ямар төвшинд байгааг харуулах бодит жишээ мөн. Сэтгүүлчийн ур чадварын шалгуурын гол үзүүлэлтийн нэг бол ямар ч алдаагүй зөв найруулан бичих чадвар бөгөөд энэ асуудалд идэвхтэн бичигчээс эхлээд ХМХ-үүдийн эзэд, сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллага хүртэл хаана хаанаа онцгой анхаарах цаг болжээ. Сэтгүүлч бэлтгэдэг хувийн ба хувьсгалын хэдэн сургуулийг шүүмжилснээр энэ асуудал бүрэн төгс шийдэгдэхгүй гэдэг нь ойлгомжтой. Хамгийн гол нь “Төрийн хэлний тухай” Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх механизмыг бий болгох шаардлагатай байна.

Сэтгүүлчдийн ур чадварт ажиглагдаж буй өөр нэг томоохон дутагдал бол сонгож авсан сэдвийн хүрээнд баримт мэдээллийг дутуу цуглуулах, дутуу цуглуулсан баримтаа дутуу боловсруулах, дутуу боловсруулсан зүйлээ өөрийнхөө үзэл бодлоор баяжуулж хэмжээнээс хэтэрсэн дүгнэлт хийж, хэт мэдэмхийрэх явдал юм. Дэвшүүлсэн асуудлаа баталж нотолж чадахгүй, хоосон цэцэрхэж, таамаглал төдий дүгнэлт хийдэг. Сэтгүүл зүй уран зохиол биш, тэр тусмаа улс төрийн илтгэл биш. Харин зорилго нь байгаа зүйлийг байгаагаар нь олон түмэнд хүргэхэд оршино. Энэ нь өнөөдөр Монголын сэтгүүл зүйг үзэл бодлын сэтгүүл зүй болгон хувиргахад нөлөөлж байна. Оросын нэрт эрдэмтэн Валерий Тишков: “Зөвлөлтийн дараах сэтгүүл зүйд большевик хэвлэл мэдээллээс үлдсэн ул мөр бий: тэнд сурвалжлагаас илүү үнэлэлт өгөх, сургаал хайрлах хандлага голлодог. ХМХ дэх материал болгон Барууны editorial-ийн шинжтэй, сэтгүүлч болгон шүүгч, далдыг харагч, бүхнийг мэдэгчийн үүргийг гүйцэтгэдэг болсон”⁶ гэсэнтэй санал нэг байна. Энэ бол өнөөдөр манайд болон ОХУ-д ноёрхож буй үзэл бодлын сэтгүүл зүйн хамгийн гол шинжийг товч бөгөөд тодорхой илэрхийлж чадсан дүгнэлт гэж хэлж болно.

Сэтгүүлчид харьцангуй их хүч хөдөлмөр, цаг хугацаа шаарддаг, ухаан зардаг шинжлэлт болон нийтлэл-уран сайхны бичлэгийн төрлүүдийг барьж авахаас халширдаг болсноос улиг болсон цөөхөн хэдэн бичлэгийн төрлийн хүрээнд эргэлдэж, тэднийг хэвшмэл арга

барилаар, өнгө аясаар бичих явдал амь бөхтэй оршиж байна. Тулга тойрсон хэдэн асуулт, улиг болсон хэвшмэл хэдэн өгүүлбэр, идэвхгүй үг хэллэг, ямар ч шаардлагагүй сул үг, нэг хэв загварт цутгасан юм шиг уйтгартай, үр өгөөж муутай саарал нийтлэлийг үйлдвэрлэхэд хүргэж байгаа нь манай сэтгүүл зүйн өнөөгийн дүр төрхийг харуулах нийтлэг шинж юм. Энэ бол манай сэтгүүлчдэд эрэл хайгуул, идэвх чармайлт, бас аливаа үзэгдэл баримтын цаад мөн чанарт нэвтрэх, шинэ зүйлийг мэдрэх чадвар, мэргэжлийн болон ерөнхий суурь мэдлэг дутаж байгаагийн бодит илрэл мөн. Ер нь манай залуу сэтгүүлчдэд бусдын бүтээлийг унших, түүнээс бүтээлчээр суралцах, алдаа дутагдлаа засаж залруулах гэсэн хүсэл эрмэлзэл туйлын хангалтгүй байгаа нь нийтлэг шинжтэй болжээ.

Эрээд оноос хойш манай сэтгүүл зүйд гадаад хэл, нэр томьёог хэт шохоорхох хандлага газар авсан нь нийтлэл, нэвтрүүлгийн хүртээмжтэй байдалд сөрөг нөлөө үзүүлэх болсон. Үүнд нэрмээс болж буй өөр нэг зүйл бол гадаад нэр томьёог буруу орчуулах, хэт махчлан орчуулж хэрэглэх явдал юм. Үүнийг доктор Б.Бирваа “Монгол хэл мөхлийн зам руугаа дөхөж яваагийн шинж нь сайхан монгол хэлээрээ яриад сурсан үг яриагаа умартаад, харийн хэлний үг яриаг эрдэм номтой, соёлтойн тэмдэг хэмээн эндүүрч буйд оршино. ...Монгол хэлээ хагас дутуу сурсан хүмүүсийн гадаад хэлнээс махчлан хөрвүүлсэн орчуулгын гайгаар монгол хэлэнд буруу хэллэг их нэвтэрч байна” гэж дүгнэсэнтэй санал нэг байна. Эх

захаа алдсан гадаад үг хэллэг хэмжээнээс хэтэрч, жирийн уншигч залхаж гүйцсэнийг олон жишээ баримтаар тайлбарлаж болно. Сэтгүүлчдийн гадаад хэлний мэдлэгийг сайжруулах, найруулан бичих, хянан боловсруулах чадварыг эрс дээшлүүлэхгүйгээр энэ асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.

Сэтгүүлчдийн ур чадварт сөрөг нөлөө үзүүлж буй өөр нэг хүчин зүйл бол аливаа баримтыг боловсруулан бичихдээ бусдын анхаарлыг татах, сэтгэл зүйд нь нөлөөлөх зорилгоор ургуулан бодсон, хачирлаж давсалсан зүйлээр хүч нэмэх, зарим хэсгийг зохиож бичих, өөрийн үзэл бодлоор баяжуулах явдал юм. Мөн уншигчдын анхаарлыг эх бичвэрт хандуулах зорилгоор хэт сүржин, уншигчийг “уриалан дуудсан” (Баруунд “хашгирсан гарчиг” гэж нэрлэдэг) гарчиг өгөх, эх бичвэр гарчиг хоёр хоорондоо зөрчилдөх, хэт нуршуу гарчиг өгөх тохиолдол ч нийтлэг шинжтэй болжээ.

Хэдийгээр энэ нь уншигчийн сэтгэл зүйгээр тоглох замаар сониноо борлуулах гэсэн тухайн сонины редакцийн арга мэх боловч цаана нь мянга мянган уншигч, захиалагчийн эрх ашиг хохирч байгаа нь тодорхой юм. Энэ нь нэг талаар зохиогчийн хэлэх гэсэн үндсэн санааг бүдгэрүүлэх, бичвэрээ үр өгөөжгүй болгох, нөгөө талаар уншигчдыг төөрөгдүүлэх, хоёрдмол санаа төрүүлэхийн зэрэгцээ эцэст нь сэтгүүл зүйн мэргэжлийн төвшин, сэтгүүлчдийн нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлж байна. Үүнийг ялангуяа долоо, арван хоногийн сонинд оршиж буй нийтлэг дутагдал гэж хэлж болно.

ОНМХ-үүдэд нийтэлж, нэвтрүүлж байгаа нийт материалуудыг агуулгын талаас бүхэлд нь авч үзэхэд сэдвийн хүрээ нэлээд яцуу байгаа нь ажиглагддаг. Судалгаанаас үзэхэд өдөр тутмын сонинууд 12-15 сэдвийн, долоо, арван хоногийн сонинууд 6-8 сэдвийн хүрээнд эргэлддэг бөгөөд аль ч сонинд улс төр, хэрэг зөрчил зэрэг цөөхөн хэдэн сэдвээр бичигдсэн материал гол байр эзэлдэг байна. Энэ бол иргэний ардчилсан нээлттэй нийгэмд үйл ажиллагаа явуулж байгаа чөлөөт хэвлэлийн хувьд туйлын хангалтгүй үзүүлэлт мөн. Аль сэдвийг голлон тусгаж, ямар асуудалд анхаарлаа хандуулах нь нэг талаар тухайн редакцийн нийтлэлийн бодлого, байр суурь, онцлогтой шууд холбоотой боловч, нөгөө талаар сэтгүүлчийн ур чадвартай холбон үзэхээс өөр аргагүй юм. Учир нь сэтгүүлчид эрэл хайгуул хийж, олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлж чадахуйц цаг үеэ олсон чухал сэдвийг сонгон авч, түүнийг ур чадварын өндөр төвшинд боловсруулж чадахгүй байна гэсэн үг. Сэтгүүлчийн ур чадвар гэдэг бол зөвхөн бичиж, боловсруулах ажлаар хязгаарлагдахгүй бөгөөд сэдвээ сонгохоос эхлээд сонин хэвлэлд нийтлэх, радио телевизээр нэвтрүүлэх хүртэлх үйл ажиллагааны аль ч шатанд гол үүрэг гүйцэтгэдэг өргөн ойлголт юм. Үнэхээр олон нийтийн сонирхлыг татахуйц сэдвийг сонгон авч, шаардлагатай бүх баримт мэдээллийг цуглуулж чадаагүй нөхцөлд сайн нийтлэл бичих, нэвтрүүлэг бэлтгэх боломжгүй гэдэг сэтгүүл зүйн практикаар батлагдсан зүйл. Нөгөө талаар олж

авсан сэдвийг өөрийн болгох, тодорхой нэг бичлэгийн төрөл, зүйлийн хүрээнд боловсруулан бичих, агуулга ба хэлбэрийн нэгдлийг өндөр төвшинд хангах асуудал бол дадлага туршлага, бичих авьяасаас гадна сэтгүүлчээс зөвхөн мэргэжлийн төдийгүй ерөнхий суурь мэдлэг шаардах болно. Тиймээс өнөөдөр дэлхий дахины сэтгүүл зүйн өмнө сэтгүүлчдэд хос мэргэжил эзэмшүүлэх (сэтгүүлч-эдийн засагч, сэтгүүлч-эрх зүйч, сэтгүүлч-экологич, сэтгүүлч-инженер г.м.), тодорхой нэг сэдэв болон бичлэгийн төрлөөр мэргэшүүлэх шаардлага хурцаар тавигдаж байна. Ийм тодорхой нэг сэдэв, эсвэл төрөл зүйлээр нарийн мэргэжсэн сэтгүүлчид томоохон амжилтанд хүрч, сэтгүүл зүйн түүхэнд ул мөрөө үлдээсэн түүхтэй юм. Тухайлбал, Унгарын Эгон Эрвин Киш (үйл явдлын сурвалжлага), Оросын В.Песков (экологийн сэдэв, сурвалжлага), В.Гиляровский (сурвалжлага, нийгмийн эмзэг бүлгийн асуудал), Америкийн Ларри Кинг (ярилцлага), Карл Бернштейн, Воб Вудворд (улс төр, албан тушаалын гэмт хэрэг) зэрэг олон сэтгүүлчийг нэрлэж болно.

Манай сэтгүүл зүйн түүхэнд нэг сэдвээр, эсвэл нэг төрөл зүйлээр дагнан бичиж томоохон амжилтанд хүрч байсан уламжлал байсныг Б.Ринчен, М.Бизьяа, С.Дашдэндэв (найруулал), Н.Иштавхай,

М.Гүрсэд (шог найруулал), Л.Түдэв, Г.Дэлэг (аян замын тэмдэглэл), Х.Цэвлээ (дурсамж тэмдэглэл), Ц.Балдорж, Ш.Цэен-Ойдов (асуудал дэвшүүлсэн өгүүлэл) зэрэг сэтгүүлчдийн бүтээлээс тодорхой харж болно. Ерээд оноос ийм уламжлал, туршлага нэлээд бүдгэрэх хандлагатай болсон юм. Харин сүүлийн жилүүдэд Ш.Цэрэнпил (хөрөг найруулал), Ш.Гүрбазар (теле ярилцлага), Ж.Мягмарсүрэн (экологийн асуудал), Б.Цэнддоо (шог найруулал) Б.Ганчимэг (ярилцлага), Б.Золбаяр, Ж.Гангаа (аян замын тэмдэглэл, эссе), Г.Дашрэнцэн (улс төр, эдийн засаг), Б.Цэвээнхэрлэн (экологи) зэрэг манай зарим сэтгүүлч тодорхой нэг сэдэв, эсвэл төрөл зүйлээр мэргэших оролдлого хийж байгаа нь дэмжүүштэй эхлэл бөгөөд үүнийг цаашид сэтгүүлч бүр, редакци болгон анхаарч нэврүүлэх хэрэгтэй юм. Энэ бол нийтлэлийн сэдвийн хүрээг өргөжүүлэх, чанар, ур чадварыг сайжруулахад чухал нөлөө үзүүлэх болно.

Сэтгүүлчийн ур чадварт сөрөг нөлөө үзүүлж буй өөр нэг зүйл бол сүүлийн жилүүдэд нийтлэл, нэвтрүүлгийг хэн нэгний захиалгаар бичих, бэлтгэх, далд сурталчилгаа хийх, хувийн ашиг сонирхлын үүднээс бичих, мэдээллийг шударга бус аргаар олж авах, заримдаа санаанаас зохиож бичих, тухайн ХМХ болон сэтгүүлчийн мэргэжлийг ашиглан бусдыг

«
Сэтгүүлчдийн ур чадварт сөрөг нөлөө үзүүлж буй өөр нэг хүчин зүйл бол аливаа баримтыг боловсруулан бичихдээ бусдын анхаарлыг татах, сэтгэл зүйд нь нөлөөлөх зорилгоор ургуулан бодсон, хачирлаж давсалсан зүйлээр хүч нэмэх, зарим хэсгийг зохиож бичих, өөрийн үзэл бодлоор баяжуулах явдал юм.

»

дарамтлах, сүрдүүлэх, ашиг олох хэрэгсэл болгох зэрэг хариуцлагагүй, ёс зүйгүй хандлага нэлээд өргөн дэлгэрсэн явдал юм. Энэ бол сэтгүүл зүйн нэр хүндийг унагаах, олон нийтийн итгэл алдрах, мэдээллийн тэнцвэрт байдал алдагдах, хүлээн авагчдад сэтгүүл зүйн талаар буруу зөрүү ойлголт өгөх, зөвхөн хэсэг бүлэг хүмүүсийн ашиг сонирхлыг хамгаалах, тэдний гар хөл болж сэтгүүл зүй олон нийтийг үнэн бодит мэдээллээр хангах үндсэн үүргээ умартахад хүргэж байна. Үүнийг чөлөөт сэтгүүл зүйг жам ёсоор нь хөгжүүлэхэд учирч буй хамгийн том бэрхшээлийн нэг гэж хэлж болно. Ийм үйлдэл үргэлж далд явагддаг учраас амархан мэдэх, ил гаргах боломжгүй байдаг.

Ө нөөдөр манай нөлөө бүхий хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн ихэнх нь өнгөн дээрээ чөлөөт байдлыг тунхаглаж, шударга царай гаргаж, хариуцлага, шударга ёсыг бамбай болгодог мөртлөө цаад утгаараа хамгийн хариуцлагагүй, хамгийн ёс зүйгүй сэтгүүлчдийн болон ХМХ-үүдийн бүлэглэлийг бий болгоход гол үүрэг гүйцэтгэж байгаа нь нууц биш юм. Нөгөө талаар энэ нь сэтгүүл зүйн үнэн бодитой, хүнлэг байх, мэдээллийн тэнцвэрт байдлыг хадгалах, хүртээмжтэй байх зэрэг үндсэн зарчмыг уландаа гишгэж, үзэг нь хурц, үг нь мэргэн байх учиртай сэтгүүлч хүн чанараа алдаж, хатуухан хэлбэл “биез үнэлэгч”, “хөлсний бичээч” болон хувиргаж, нийгэмд билгийн нүдээр биш, зоосны нүхээр харахад хүргэж байна. Энэ бол улс төр бохир заваан, нийгмийн тогтолцоо гажигтай, хүлээн авагчдын ихэнх хэсэг нь хараахан

нийгэмшээгүй, ухамсрын төвшин доогуур байгаатай ч холбоотой юм. Өөрөөр хэлбэл нийгмийн зүгээс ХМХ-д тавих шаардлага сул, хэт хүлцэнгүй, ямар ч мэдээллийг сохроор хүлээн авдаг нь ийм замбараагүй, хязгааргүй эрх чөлөөтэй сэтгүүлч, ХМХ-үүдийг улам өөгшүүлж, дураараа загнаж, эрх танхил хүүхэд шиг аашлахад хүргэж байна гэж хэлж болно. Зүй нь ардчилсан соёлтой орнуудын ушигчид, хүлээн авагчид шиг алдаа гаргасан, буруу зөрүү зүйл нийтэлсэн, бусдын нэр хүндэд халдсан тохиолдолд тухайн сониноо захиалахаа, худалдан авахаа шууд зогсоож, радио, телевизээ унтраагаад зохих газарт нь гомдол мэдүүлэх ёстой юм.

Энэ бол ХМХ-үүдийг хариуцлагатай, сэтгүүлчдийг ёс зүйтэй болгодог цорын ганц арга, хэрэгсэл бөгөөд үүнийг сэтгүүл зүй судлаачид, туршлагатай сэтгүүлчид нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг байна. Өөрөөр хэлбэл амьдрах эдийн засгийн эх үүсвэрээ алдахгүй байхын тулд ХМХ-үүд шударга, хариуцлагатай байхаас өөр замгүй болтол нь хашрааж чадаж байна гэсэн үг юм. Манай сэтгүүл зүй ч, олон түмэн ч хариуцлагын ийм тогтолцоо руу шилжих шаардлагатай байна.

Сэтгүүлч уран бүтээлчдийн ур чадварт ажиглагдаж буй өөр нэг дутагдал бол тусгаж байгаа асуудалд ямар ч бэлтгэлгүй, судалгаагүй хандах, зөвхөн гадна талаас нь өнгөцхөн мэдээлэх, үүнээс улбаалан таамаглал дэвшүүлэх, ямар ч баталгаа нотолгоогүй зүйлийг яарч мэдээлэх явдал нэлээд түгээмэл юм. Аливаа эргэлзээтэй, цуурхлын шинжтэй баримт мэдээллийг

хоёр дахь, гурав дахь эх сурвалжаар баталгаажуулахгүйгээр шууд нийтэлж, нэвтрүүлдэг учраас янз бүрийн хэрүүл маргаан дагуулах, шүүхэд дуудагдах тохиолдол ч цөөнгүй гарч байна.

Энэ бүхэн нь “баттай эх сурвалжийн мэдээлснээр”, “...гэж эх сурвалжууд мэдээлж байна”, “тэгсэн бололтой”, “тэгсэн гэнэ”, “тийм түүхтэй гэдэг”, “хүмүүс дургүйцэж байна” гэх мэтээр төгсгөсөн мэдээ материал хэт олшрох хандлагатай байна. Сэтгүүлч өөрөө сайн судалж, үнэн мөнийг баталсан бол ингэж бичихгүй гэдэг нь тодорхой. Энэ нь уншигчид хоёрдмол санаа төрүүлэх, буруу зөрүү мэдээлэл өгөх, будлиулах гол шалтгаан болохын хамт ХМХ-д хандах хандлагыг үндсээр нь өөрчлөхөд хүртэл нөлөөлж болно.

Барууны сэтгүүл зүйд таамаглалын шинжтэй, ямар нэгэн эргэлзээ төрүүлэхээр зүйлийг хэзээ ч нийтэлж, нэвтрүүлэхгүй. Тиймээс ч нэрт зохиолч Карл Чапек: “Хэрэв та гучин удаа шоронд сууж гарсан халаасны хулгайчийг ч онц ноцтой гэмт хэрэгтэн гэж бичсэн бол шүүхэд заргалдсан тохиолдолд та ямар ч тайлбаргүйгээр ялагдах болно” гэж бичсэн байдаг. Энэ бол сэтгүүлч аливаа баримт, мэдээллийг сонгох, боловсруулан бичихдээ маш хариуцлагатай хандах хэрэгтэй гэдгийг илэрхийлж буй хэрэг мөн. Харамсалтай нь манай ОНМХ-ийн пркатикт ийм алдаа, дутагдал улам газар авах шинжтэй байгаад зөвхөн сэтгүүл зүй судлаачид төдийгүй жирийн ушигчид хүртэл шүүмжлэлтэй хандах болжээ.

¹ Цэвлээ Х. 2005. “Миний” сэтгүүл зүй. УБ., 49 дэх тал.

² Грабельников А. А. 2001. Работа журналиста в прессе. М., с. 72.

³ Нямсүрэн Д. 1985. Сэтгүүлчийн ур чадвар. УБ., 18 дахь тал.

⁴ Түдэв Л. 1992. Асуудал. УБ., 147-148 дахь тал.

⁵ Чернышевский Н. Г. 1978. Полн. собр. соч. Т. 4. М., с. 188.

⁶ Тишков В. СМИ и конфликты // “Независимая газета”. 1994.04.10.

⁷ Бирваа Б. Монгол хэлийг сэглэж буй өвчнүүд // “Үнэн”. 2009. 02.10. №027.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Андерсен Х., Меллит М. 2008. Нийтлэл, нэвтрүүлгийг яаж бэлтгэх вэ? (Орч. М.Зулькафиль). УБ.

2. Баасансүрэн Т. 2002. Сэтгүүлчийн уран чадварын асуудал: уламжлал ба шинэчлэл. УБ.

3. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.

4. Зулькафиль М. 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.

5. Зулькафиль М. 2009. Сэтгүүлчийн ур чадвар. Боть I. УБ.

6. Менчер М. 2001. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. УБ.

7. Норовсүрэн Л. 2006. УБ. Монголын нийтлэл.

8. Нямсүрэн Д. 1985. Сэтгүүлчийн ур чадвар. УБ.

9. Рэндалл Д. 2002. Яаж сайн сэтгүүлч болох вэ? (Орч. М.Зулькафиль). УБ.

10. Цэвлээ Х. 2004. “Миний” сэтгүүл зүй. УБ.

11. Горехов В. М. 1984. Основы журналистского мастерства. М.

12. Черепанов М. С. 1988. Таинство мастерства журналиста. М.

Резюме

В статье автор, опираясь на теоретико-методологические положения современной массовой коммуникации, раскрывает суть понятия "мастерство журналиста" и показывает его некоторые особенности на примере монгольских газетных публикаций.

Автор на основе конкретных примеров СМИ подробно показывает те изменения, которые произошли в творчестве отечественных журналистов в процессе формирования демократической журналистики в Монголии. Также автор подробно останавливается на тех факторах, влияющих на содержание и формы газетных выступлений и радио-, телепрограмм.